



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 35 (512)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны есдүгээр сарын 21

№35 (512)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

460.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 200	865
461.	Чойжилжавын Цэдэнбалд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 201	868
462.	Должинхүүгийн Цэрэндолгорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 202	868
463.	Пунцагийн Батаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 203	868
464.	Тамжавын Тавхайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 204	869
465.	Данзангийн Хишигсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 205	869
466.	Цэрэнсономын Сандаг-Очирт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 206	869
467.	Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр Д Батсүхийг томилох тухай	Дугаар 208	869

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

468.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 175	870
------	--------------------------------	------------	-----

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

469.	Иргэний зарим хэргийн харьяаллыг захиргааны хэргийн харьяаллаас зааглан ялгах тухай Дээд шүүхийн 32 дугаар тогтоолын хавсралтын үргэлжлэл		882
------	---	--	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Боловсролын салбарт болон ҮЭ-ийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан зарим хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | |
|---|---|
| 1. Дашийн Бэгзжав - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор сургуулийн зөвлөх багш | сургуулийн зөвлөх багш |
| 2. Дэлэгийн Түмэнжаргал - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор | 3. Дамдингийн Цэндээ - МҮЭ-үүдийн холбооны Эрдэм шинжилгээ сургалтын төвийн захирал |

АЛТАН ГАДАС ОДОНГООР

1. Цэдэннямын Нямжав - МУБИС-ийн Багшийн сургуулийн математикийн багш
2. Дахшоролын Базарсүрэн - Завхан аймгийн Уластай сумын 10 жилийн II сургуулийн биеийн тамирын багш
3. Лийрэвийн Бадам - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор сургуулийн багш
4. Номхоны Баасандулам - Нийслэлийн Баянгол дүүргийн 47 дугаар дунд сургуулийн орос хэлний багш
5. Зундуйн Баасанчулуун - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 3 дугаар сургуулийн захирал
6. Рэгсүрэнгийн Бат-Эрдэнэ - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны газрын дарга
7. Самбуугийн Бадамцэцэг - Монголын ажилтан, албан хаагчдын ҮЗ-ийн холбооны зохион байгуулагч
8. Доржийн Болд - Эрчим хүч, Геологи, уул уурхайн ажилчдын ҮЗ-ийн холбооны нарийн бичгийн дарга
9. Шанжмятавын Буянаа - Монголын Төмөр замчдын ҮЗ-ийн холбооны дэд дарга
10. Дамбийн Бямбарагчаа - МҮЭ-үүдийн холбоонд Ордны жижүүр
11. Даваасамбуугийн Бямбадоо - Баянхонгор аймгийн 11 жилийн 1 дүгээр сургууль "Номундалай" цогцолборын биологийн багш
12. Самбуугийн Гэрэлмаа - МҮЭ-ийн соёлын төв ордны захирал
13. Дашийн Гантөмөр - Говьсүмбэр аймгийн ҮЗ-ийн холбооны дарга
14. Рагчаагийн Дархижав - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургуулийн физикийн багш
15. Галбадрахын Даваажаргал - ШУТИС-ийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн проректор
16. Цэмбэлийн Даржаа - МУИС-ийн химийн факультетийн багш
17. Гэлгээгийн Дансмаа - Хөвсгөл аймгийн Хатгал сумын 10 жилийн сургуулийн бага ангийн багш
18. Дүйнхорын Дацдондог - Хэнтий аймгийн Галшар сумын дунд сургуулийн бага ангийн багш
19. Отгоны Дэмбэрэл - Өмнөговь аймгийн ҮЗ-ийн холбооны нягтлан бодогч
20. Баатарын Замбал - Увс аймгийн Улаангом сумын "Эрдмийн-Оргил" цогцолбор сургуулийн багш
21. Даваажавын Ичинорлоо - Ховд аймгийн Жаргалант сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш
22. Мужааны Мөнхжаргал - МУБИС-ийн Багшийн сургуулийн математикийн багш
23. Дагвын Нацагдорж - Дархан-Уул аймгийн ҮЗ-үүдийн холбооны дарга
24. Очирын Норзон - Монголын хувийн хэвшлийн ҮЗ-үүдийн холбооны ахмад ажилтан
25. Батжаргалын Мядагмаа - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын өндөр настан, ахмад багш
26. Цэдэндоржийн Нарантуяа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр сургуулийн багш
27. Цэжингийн Цэвээнгэрэл - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор сургуулийн ахмад багш
28. Шадравын Цэдэв - Нийслэлийн 23 дугаар дунд сургуулийн сургалтын менежер
29. Дуламрагчаагийн Пүрэвдорж - Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургуулийн багш
30. Дэндэвийн Сандагдорж - Дундговь аймгийн 3 дугаар дунд сургуулийн багш
31. Балааганы Содномдаржаа - Ховд аймгийн Мест сумын 11 жилийн дунд сургуулийн сургалтын менежер
32. Оргойн Сэргэлэн - ЭМШУИС-ийн Анагаах ухааны сургуулийн мэс заслын тэнхмийн эрхлэгч
33. Раднаагийн Сүхбаатар - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 26 дугаар сургуулийн математикийн багш
34. Чулууны Төмөр - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Хүмүүн" цогцолборын 2 дугаар сургуулийн математикийн багш
35. Хандсүрэнгийн Тунгалаг - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 31 дүгээр сургуулийн эрхлэгч
36. Дондогийн Тогтохбазар - Хэнтий аймгийн Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн ҮЗ-ийн хорооны дарга
37. Алтангэрэлийн Уранбилэг - Булган аймгийн төвийн 11 жилийн 1-р сургуулийн биологийн багш
38. Банзрагчийн Уранчимэг - Өмнөговь аймгийн Гурвантэс сумын дунд сургуулийн бага ангийн багш
39. Таяагийн Халтар - Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн багш
40. Хабышийн Ховдэш - Баян-Өлгий аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн биеийн тамирын багш
41. Чойжилын Цэнд-Аюуш - Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны ундраа" цогцолбор сургуулийн нийгмийн ухааны багш

42. Палчийн Чулуун - Говь-Алтай аймгийн 11 жилийн 1 дүгээр сургуулийн технологийн багш
43. Чүлтэмийн Чойж - Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЗ-үүдийн холбооны дэд дарга.
44. Нямсүрэнгийн Эрдэнэхүү - МҮЭ-үүдийн холбооны санхүүгийн хэлтсийн эрхлэгч, ерөнхий

нягтлан бодогч

45. Дашзэвэгийн Энэбиш - МУБИС-ийн Биеийн тамирын сургуулийн тэнхмийн эрхлэгч
46. Батцэндийн Эрдэнэ - Дархан-Уул аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуулийн захирал

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ

1. Чулууны Адыа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 74 дүгээр сургуулийн бага ангийн багш
2. Содномын Ариухан - Увс аймгийн Зүүнговь сумын цэцэрлэгийн эрхлэгч, багш
3. Нанзаддоржийн Баасанжав - Ховд аймгийн Жаргалант сумын 11 жилийн 3 дугаар сургуулийн физикийн багш
4. Чойнжоогийн Баатар - Дорнод аймаг МСҮ төвийн дадлагын мастер багш
5. Бэлэгийн Батмөнх - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор сургуулийн багш
6. Мижиддоржийн Батцроож - Орхон аймгийн ҮЗ-ийн холбооны дарга
7. Даваадоржийн Баянмөнх - Завхан аймгийн Б.Элдэв-Очирын нэрэмжит I арван жилийн сургуулийн математикийн багш
8. Пүрэвжавын Баяраа - Завхан аймгийн I сургуулийн хүмүүжлийн эрхлэгч, нийгмийн ажилтан
9. Тавхайн Борис - Орхон аймгийн Монгол Оросын хамтарсан Барилгын Стройинвест компанийн ҮЗ-ийн хорооны дарга
10. Хайдавын Борчулуун - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр 10 жилийн дунд сургуулийн бага ангийн багш
11. Чоймзонгийн Бум-Очир - Баянхонгор аймгийн Шинэ Жинст сумын дунд сургуулийн технологийн багш
12. Моломжамцын Гангаа - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн газар зүйн багш
13. Рэнчиндоржийн Гэнзүл - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 68 дугаар сургуулийн бага ангийн багш
14. Базарын Гансүх - Ховд аймгийн Жаргалант сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн математикийн багш
15. Чойжилсүрэнгийн Даваажав - УБТЗ-ын төв эмчлэлийн ҮЗ-ийн хорооны дарга
16. Дамдинсүрэнгийн Даваасүрэн - ЭМШУИС-ийн хүүхдийн анагаахын тэнхмийн ахлах багш
17. Буухүүгийн Дашдаваа - Баянхонгор аймгийн Шинэ Жинст сумын дунд сургуулийн математикийн багш

18. Даржаагийн Долгорсүрэн - Монголын хувийн хэвшил ҮЗ-үүдийн холбооны зохион байгуулагч
19. Магсаржаламын Лхамдолгор - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
20. Даваагийн Намжил - МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш
21. Гүржавын Наран - ЭМШУИС-ийн Анагаах ухааны сургуулийн багш
22. Чагнаагийн Нарантуяа - Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын ҮЗ-ийн хорооны дарга
23. Цамбын Нэргүй - Ховд аймгийн Мөст сумын 11 жилийн дунд сургуулийн бага ангийн багш
24. Батаагийн Нямсүрэн - Төв аймгийн Сүмбэр сумын дунд сургуулийн захирал
25. Рэмжээгийн Орших - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолборын ахлах сургуулийн захирал
26. Доржпаламын Оюун - Төв аймгийн ҮЗ-ийн холбооны дэд дарга
27. Бадамжавын Оюунчимэг - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн математикийн багш
28. Дамдинсүрэнгийн Оюунчимэг - Дорнод аймгийн Халх гол сумын дунд сургуулийн захирал
29. Шаравын Сэтэв - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвийн албан бус сургалтын багш
30. Нацагдоржийн Тунгалаг - МУИС-ийн эдийн засгийн сургуулийн багш
31. Пунцагийн Үл-Олдох - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор сургуулийн бага ангийн багш
32. Мөнхөөгийн Хараацайхүү - Төв аймгийн Сүмбэр сумын дунд сургуулийн бага ангийн багш
33. Авилмажины Ховдабай - Ховд аймгийн Ховд сумын 11 жилийн дунд сургуулийн орос, казак хэл, уран зохиолын багш
34. Хишигийн Цэнд - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолбор сургуулийн ахмад ажилтан
35. Вандансанжийн Цэрэндорж - Орхон аймаг Eagle сургуулийн математикийн багш
36. Цогтын Чимгээ - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолборын бага ангийн багш

37. Дашцэдэнгийн Чулуунцэцэг - Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын газрын сургуулийн өмнөх байгууллагын арга зүйч

38. Мишигдоогийн Чимэдцогзол - Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын дунд сургуулийн бага ангийн багш

39. Жанхарын Шараа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 88 дугаар дунд сургуулийн захирал

40. Цэрэндуламын Шинэхүү - Өмнөговь аймгийн Гурвантэс сумын дунд сургуулийн бага ангийн багш

41. Ламжавын Энх-Амгалан - "Мандах бүртгэл" дээд сургуулийн дэд захирал

42. Цэдэндамбын Энхтайван - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэгийн дуу хөгжмийн багш

43. Бадгарын Эрхэмбаяр - Ховд аймгийн Мөнххайрхан сумын 11 жилийн дунд сургуулийн дотуур байрны багш

44. Сундуйн Эрхэмбаяр - Увс аймгийн Улаангом сумын "Эрдэм-Оргил" цогцолборын ахлах сургуулийн багш

45. Шаравын Янжинлхам - Төв аймгийн Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн нярав

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Чойжилжавын Цэдэнбалд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Монгол Улсын боловсролын салбарт олон жил ажиллаж, сургалтын арга зүйг боловсронгуй болгох, сургуулийн сургалтын болон санхүүгийн менежментийг сайжруулах талаар санаачилгатай ажиллан, эрдэм судлалын болон заах аргын зөвлөмж, аргачлал олсныг боловсруулсан МУБИС-

ийн Багшийн сургуулийн захирал Чойжилжавын Цэдэнбалд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Должинхүүгийн Цэрэндолгорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж математик-физикийн сургалт, заах аргад шинэ арга зүйг нэвтрүүлэх болон сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, залуу багш нарыг халамжлан хүмүүжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Хан-Уул

дүүргийн Биокомбинат дахь 10 дугаар дунд сургуулийн зөвлөх багш Должинхүүгийн Цэрэндолгорт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар хот

Пунцагийн Батаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Дээд боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж гадаадын эрдэмтэдтэй хамтран олон улсын төсөл хэрэгжүүлэн, эрдэм шинжилгээний экспедиц зохион байгуулж, социологийн судалгаа хийхийн зэрэгцээ олон арван сурах бичиг, ном, эрдэм шинжилгээний бүтээл

туурвисан ХААИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч Пунцагийн Батаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

Тамжавын Тавхайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Орон нутгийн боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлж, сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх талаар амжилт гарган сүүлийн 5 жилд удирдсан сургуулийн багш, сурагчид нь улс, аймгийн олимпиадаас 65 медаль, урлаг спортын 35 медаль хүртэж, аймгийн үлгэр жишээ шилдэг

менежменттэй сургуулиар шалгарсан Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Мэргэд" сургуулийн захирал Тамжавын Тавхайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Данзангийн Хишигсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Сургалтын технологийг боловсронгуй болгох, шинэ арга зүйг нэвтрүүлэх талаар олон жил санаачилгатай ажиллаж, "Сурагчдыг алдаагүй зөв бичүүлж сургая", "Найруулгын алдаа түүний ангилал" зэрэг олон ном, заах аргын материал боловсруулж сургалтанд нэвтрүүлэн, сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх талаар гаргасан

амжилтыг нь үнэлж Нийслэлийн 23 дугаар дунд сургуулийн Монгол хэл-Уран зохиолын багш Данзангийн Хишигсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

Цэрэнсономын Сандаг-Очирт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан дэлхийн ба үндэсний сонгодог бүтээлүүд, ардын болон зохиолын дуунуудыг мэргэжлийн өндөр түвшинд дуулж, театрын жүжиг, уран сайхны киноны гол дүрүүдийг чадварлаг бүтээн, уран бүтээлийнхээ санг баяжуулж, Монголын соёл урлагийг өөрийн орон төдийгүй гадаад орнуудад сурталчилахад оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Архангай аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол дуучин Цэрэнсономын Сандаг-Очирт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр Д.Батсүхийг томилх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Прокурорын байгууллагын тухай" хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын Ерөнхий прокурорын саналыг

үндэслэн Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч Доржсүрэнгийн Батсүхийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн 17 дугаар хавсралт, Иргэний нисэхийн тухай хуулийн 6.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний хөтөлбөр (журал) батлах тухай" Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 215 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Ц.ЦЭНГЭЛ

Засгийн газрын 2007 оны 175 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нисэхийн аюулгүй байдлын дүрэм, журам, үйл ажиллагааны горимыг хэрэгжүүлэх замаар иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр (цаашид "Үндэсний хөтөлбөр" гэнэ)-ийн зорилго оршино.

1.2. Үндэсний хөтөлбөр нь дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгч, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа нисэх буудлын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зорилго нь зорчигч, агаарын хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээ болон хилийн хяналтын байгууллагын ажилтан, иргэн, түүнчлэн агаарын хөлөг, нисэх буудлын байгууламж, тоног төхөөрөмжийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад оршино.

1.4. Үндэсний хөтөлбөрийг 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотноо батлагдсан Олон улсын иргэний нисэхийн тухай конвенци болон түүний Хавсралт 17 (Аюулгүй байдал), Хавсралт 2 (Нислэг үйлдэх журам), Хавсралт 6 (Агаарын хөлгийн ашиглалт), Хавсралт 9 (Үйл ажиллагааг хялбарчлах), Хавсралт 10 (Нисэхийн холбоо), Хавсралт 13 (Агаарын хөлгийн осол, сүйрлийг шинжлэн шалгах), Хавсралт 14 (Аэродром)-т тусгагдсан нисэхийн аюулгүй байдалтай холбоотой олон улсын стандарт болон зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан болно.

1.5 Энэ хөтөлбөрт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1. "агаарын навигацыйн байгууламж" гэж агаарын хөлгийн байршлыг тодорхойлох, хөдөлгөөнийг удирдан чиглүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд ашиглагдах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг;

1.5.2. "агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр" гэж зорчигч, агаарын хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээний ажилтан, түүнчлэн агаарын хөлгийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор үндэсний хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан агаарын тээвэрлэгч байгууллага, эсхүл түүний төлөөлөгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон баримт бичгийг;

1.5.3 "агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлс" гэж агаарын тээвэрлэгчийн дотоод үйл ажиллагаанд зориулагдсан өөрийн, эсхүл гэрээт байгууллагад хүргүүлэх зорилгоор тээвэрлэгдэх бичиг баримт, хангамжийн материал, техник үйлчилгээний сэлбэг, нислэгийн хоол хүнс, цэвэрлэгээний болон бусад зүйлсийг;

1.5.4 "агаарын хөлгийн аюулгүй байдлын үзлэг" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй аюултай хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зэвсэг болон сэжигтэй зүйл илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор талд хийх үзлэгийг;

1.5.5 "агаарын хөлгийн аюулгүй байдлын шагналт" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй аюултай хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зэвсэг болон сэжигтэй зүйл илрүүлэх зорилгоор

агаарын хөлгийн гадна болон дотор талд хийх шалгалтыг;

1.5.6. "агаарын хөлгийн зогсоол" гэж агаарын хөлгийг байгуулахад зориулагдсан перроны хэсэг, талбайг;

1.5.7. "агаарын хөлгийн техник үйлчилгээний талбай" гэж агаарын хөлгийн техник үйлчилгээнд зориулагдсан перрон, ангар, засварын цех, тээврийн хэрэгслийн зогсоол, тэдгээрийг холбосон зам, байгууламжийг;

1.5.8. "анкет шалгах" гэж аюулгүй байдлын хяналтын ажилтныг ажилд авахад, эсхүл аюулгүй байдлын хяналтын ажилтныг дагалдуулахгүйгээр хориотой бүсэд нэвтрэх этгээдийн биеийн байцаалт, ажлын туршлага, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх зэргийг нягтлахыг;

1.5.9. "ачаа" гэж агаарын хөлөгт тээвэрлэх шуудан, эд зүйлс, тээшнээс бусад зүйлийг;

1.5.10. "ачааны барилга байгууламж" гэж ачааг агаарын болон газрын тээврийн хооронд дамжуулах, шилжүүлэх, тээвэрлэхийн өмнө хадгалах зориулалтын байгууламжийг;

1.5.11. "аюулгүй байдлын аудит" гэж үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх шалгалтыг;

1.5.12. "аюулгүй байдлын үзлэг" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эзвэсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай зүйлсийг илрүүлэхэд чиглэсэн техникийн болон бусад арга хэрэгслээр хийх үзлэгийг;

1.5.13. "аюулгүй байдлын сорилт" гэж хөндлөнгийн хууль бус үйлдлийн хэлбэрээр нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагааг ил болон далд шалгахыг;

1.5.14. "аюулгүй байдлын судалгаа" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэл хийх боломж бүрдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагаанд хийх үнэлгээ, илэрсэн дутагдлыг засаж залруулах зөвлөмжийн хамт;

1.5.15. "гар тээш" гэж зорчигч өөрөө хариуцан биедээ авч явахыг зөвшөөрсөн агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт тээвэрлэх тээшийг;

1.5.16. "дамжин өнгөрөх зорчигч" гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөрөө нислэгээ цааш үргэлжлүүлж байгаа зорчигчийг;

1.5.17. "дамжин өнгөрөх тээш" гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөс буулгалгүй цааш үргэлжлүүлэн тээвэрлэх тээшийг;

1.5.18. "дипломат тээш болон илгээмж" гэж 1961 онд Вена хотноо батлагдсан Дипломат харилцааны тухай конвенцийн дагуу тээвэрлэгдэх дипломат шуудан болон материалыг;

1.5.19. "нийтийн эзэмшлийн бүс" гэж ямар нэг зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй орж гарч

болох нисэх буудлын барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

1.5.20. "нислэгийн үеийн аюулгүй байдлын ажилтан" гэж агаарын тээвэрлэгчийн харьяалах улсын Засгийн газраас, эсхүл өөр хэлэлцэн тохироч улсын Засгийн газраас агаарын хөлөг болон түүн дотор байгаа хүмүүсийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор тухайн агаарын хөлөгт зорчихоор томилогдсон бөгөөд тусгай сургалтад хамрагдсан этгээдийг ойлгоно. Агаарын хөлөгт нэг буюу хэсэг хүмүүсийг тусгайлан хамгаалахаар томилогдсон этгээдийг үүнд хамааруулахгүй.

1.5.21. "нисэх буудлын аюулгүй байдлын хороо" гэж нисэхийн аюулгүй байдлыг хангах болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нисэх буудлын аюулгүй байдал хариуцсан албан тушаалтанд зөвлөгөө өгөх хороог;

1.5.22. "нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллага" гэж Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийг боловсруулах, өөрчлөх санал гаргах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг;

1.5.23. "нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр" гэж хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор үндэсний хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан нисэх буудалд хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон баримт бичгийг;

1.5.24. "нислэгийн үед хэрэглэгдэх эд зүйлс" гэж нислэгийн үед зорчигчийн үйлчилгээнд хэрэглэх, эсхүл худалдах эд зүйлсийг;

1.5.25. "олон улсын нисэх буудал" гэж хилийн боомт бүхий нисэх буудлыг;

1.5.26. "онцгой анхаарлын цэг" гэж гэмтсэн болон устгагдсаны улмаас иргэний нисэхийн үйл ажиллагаанд ноцтой саад учруулж болзошгүй нисэх буудлын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг;

1.5.27. "перрон" гэж зорчигчийг суулгах болон ачаа, шууданг ачих, буулгах, шатахуунаар цэнэглэх, техник үйлчилгээ хийх, агаарын хөлгийг байрлуулах зориулалт бүхий аэродром дахь талбайг;

1.5.28. "тусгай зориулалтын нислэг" гэж хөдөө аж ахуй, барилга байгууламж, зураг авах, хайгуул, ажиглолт, эргүүл, эрэн хайх, авран туслах, зар сурталчилгаа зэрэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор гүйцэтгэж байгаа нислэгийг;

1.5.29. "тэсрэх бөмбөгөөр заналхийлэх" гэж нислэг үйлдэж байгаа, эсхүл гэзэрт байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа болон нисэх буудал, иргэний нисэхийн байгууламж, хувь хүнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюул учирч болзошгүй талаар эзэнтэй, эсхүл эзэнгүй, үнэн, эсхүл худал мэдээллээр заналхийлэхийг;

1.5.30. "тээш" гэж агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэгдэх зорчигчийн тээшийг;

1.5.31. "тээш ялгах талбай" гэж тээвэрлэх тээшийг аяллын дугаар, чиглэлээр нь ялгах талбайг;

1.5.32. "үйлчилгээнд гарсан агаарын хөлөг" гэж нислэгт бэлэн болох нь баталгаажсан, тухайн аяллын дугаар олгогдсон болон зорчигчийг хүлээн авах зохих бэлтгэл хангагдан, агаарын хөлгийн диспетчерийн хяналтад орсон, зогсоолд байрласан агаарын хөлгийг;

1.5.33. "үзлэгийн дараахь бүс" гэж аюулгүй байдлын үзлэгийн цэг болон агаарын хөлгийн хоорондох хэсгийг;

1.5.34. "сэжигтэй эд зүйлс" гэж эзэнгүй, эсхүл эзнийг нь тогтоох боломжгүй, аюул заналхийлэл агуулсан байж болзошгүй гэж үзсэн эд зүйлсийг;

1.5.35. "хамгаалагдсан бүс" гэж аюулгүй байдлын хяналт бүхий нисэх буудлын аэродромын талбай, барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

1.5.36. "хориотой бүс" гэж аюулгүй байдлын үзлэгийн цэгээс агаарын хөлөг хүртэлх зорчигчдын танхим, тээш ялгах талбай, перрон, нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлөг, аюулгүй байдлын үзлэг хийгдсэн тээш, ачаа, шуудан болон хамгаалагдсан бүсэд байрлах нислэгийн хоол хүнс бэлтгэх газар, цэвэрлэгээний талбай зэрэг нэмэлт хяналт шаардлагатай хамгаалагдсан бүсийн хэсгийг;

1.5.37. "хориглосон эд зүйлс" гэж агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон эсхүл зөвхөн тээвэрлэлтийн тусгай журмын дагуу тээвэрлэх хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эд зүйлсийг;

1.5.38. "хөндлөнгийн хууль бус үйлдэл" гэж иргэний нисэхийн болон агаарын тээврийн аюулгүй байдалд нөлөөлөх дараахь үйлдэл, эсхүл оролдлогыг;

- нислэг үйлдэж буй болон газарт байгаа агаарын хөлгийг булаан эзлэх;

- агаарын хөлөг болон нисэх буудалд хүн барьцаалах;

- агаарын хөлөг, нисэх буудлын хамгаалагдсан бүс болон агаарын навигацгийн тоног төхөөрөмжид зөвшөөрөлгүйгээр хүч түрэмгийлэн нэвтрэх;

- гэмт хэрэг үйлдэх зорилгоор агаарын хөлөг, нисэх буудалд зэвсэг, аюултай бодис болон эд зүйлсийг нэвтрүүлэх;

- нислэг үйлдэж буй болон газарт байгаа агаарын хөлөг, зорчигч, агаарын хөлгийн нисэх багийн гишүүд, нисэх буудлын газрын үйлчилгээний ажилтан, иргэдийн аюулгүй байдал, иргэний нисэхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж бэлэжшгүй хуурамч мэдээ, мэдээллийг тараах.

1.5.39. "хүлээн авах боломжгүй этгээд" гэж тухайн улсад нэвтрүүлэхийг эрх бүхий

байгууллагаас зөвшөөрөөгүй, эсхүл татгалзсан этгээдийг;

1.5.40. "хэв журам зөрчсөн зорчигч" гэж нисэх буудал, агаарын хөлөгт хууль тогтоомж зөрчсөн, нисэх буудлын ажилтан, нисэх баг болон багийн бусад гишүүдийн зааврыг үл даган нисэх буудал болон агаарын хөлгийн хэвийн ажиллагааг алдагдуулж буй этгээдийг;

1.5.41. "шилжин ачигдах ачаа" гэж аль нэгэн улсын нисэх буудлаас тээвэрлэгдэж ирсэн ачааг өөр нисэх буудал руу тээвэрлүүлэхээр агаарын хөлөгт шилжүүлэн ачих ачааг;

1.5.42. "шилжин ачигдах тээш" гэж агаарын хөлгөөр тээвэрлэгдэн ирж өөр агаарын хөлөгт шилжүүлэн ачих хүртэл хориотой бүсэд хадгалах тээшийг;

1.5.43. "шилжин суух зорчигч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу нислэгээ үргэлжлүүлэхийн тулд нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөгт шилжин сууж байгаа зорчигчийг;

1.5.44. "шуудан" гэж Дэлхийн шуудангийн холбооны дүрмийн дагуу шуудангийн байгууллагад хүргэгдэх захидал болон бусад зүйлсийг;

1.5.45. "эзэн нь тогтоогдоогүй тээш" гэж нисэх буудалд тээвэрлэгдэж ирсэн, зорчигч өөрийн гэж мэдүүлэхгүй тээшийг;

1.5.46. "эзэнгүй тээш" гэж тээшний зүүлттэй буюу зүүлтгүй, эзэн нь тогтоогдоогүй тээшийг.

Хоёр. Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл

2.1. Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэл, учирч болзошгүй аюул, заналхийллийн түвшинг нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллага тогтоох бөгөөд тагнуулын байгууллага мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

2.2. Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах аюулгүй байдлын арга хэмжээ нь дор дурдсан тохиолдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ:

2.2.1. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байрлуулан агаарын хөлгийг устгах буюу гэмтэл учруулахаас;

2.2.2. агаарын хөлгийг булаан эзлэх болон түүний зорчигч, нисэх багийг барьцаалахаас;

2.2.3. нислэг үйлдэж буй агаарын хөлөг, түүний зорчигч, нисэх багийн аюулгүй байдалд аюул учруулахаас;

2.2.4. хориотой болон хамгаалагдсан бүсэд хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болох зүйлс, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, эсхүл зэвсэг нэвтрүүлэхээс;

2.2.5. тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байрлуулан агаарын

навигацийн байгууламжийг устгах, гэмтээх болон иргэний нисэхийн үйл ажиллагаанд саад учруулахаас;

2.2.6. нисэх буудалд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байрлуулсан олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулахаас.

2.3. Тануулын байгууллага нь өөрийн олсон болон мэдээлэл цуглуулах эрх бүхий бусад байгууллагын ирүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, үнэлэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлнэ. Тануулын байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллага хүлээн авмагц нисэх буудал, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн бусад байгууллагад хүргүүлэн, холбогдох арга хэмжээг авна.

2.4. Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшинг Нэгдүгээр түвшин (бага эсхүл "Ногоон"), Хоёрдугаар түвшин (дунд эсхүл "Шар"), Гуравдугаар түвшин (өндөр эсхүл "Улаан") гэж тогтооно.

2.4.1. Нэгдүгээр түвшин–иргэний нисэхийн үйл ажиллагаа нь халдлагад өртөх талаар бодит мэдээ, мэдээлэл байхгүй боловч хөндлөнгийн хууль бус үйлдэл хийх боломж байгаа;

2.4.2. Хоёрдугаар түвшин–иргэний нисэхийн үйл ажиллагаа нь халдлагад өртөх магадлалтай байна гэж тодорхойлсон мэдээ, мэдээлэл байгаа;

2.4.3. Гуравдугаар түвшин–иргэний нисэхийн үйл ажиллагаа нь халдлагад өртөх талаар тусгайлан тодорхойлсон бодит мэдээ, мэдээлэл байгаа.

Гурав. Эрх зүйн үндэслэл

3.1. Үндэсний хөтөлбөрт хамаарах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц:

- "Олон улсын иргэний нисэхийн тухай" 1944 оны Чикагогийн конвенц;

- "Агаарын хөлөгт гарсан гэмт халдлага болон зарим онцгой хэргийн тухай" 1963 оны Токиогийн конвенц;

- "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай" 1970 оны Гаагийн конвенц;

- "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдэл гаргуулахгүй байх тухай" 1971 оны Монреалийн конвенц;

- "Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэглэл хийх тухай" 1999 оны Монреалийн конвенц;

- "Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай" 1999 оны Монреалийн протокол.

3.2. Энэ хөтөлбөрт хамаарах үндэсний эрх зүйн баримт бичиг:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай

хууль;
- Галт зэвсгийн тухай хууль;
- Гэрээт харуул хамгаалалтын тухай

хууль;
- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Терроризмтай тэмцэх тухай хууль;
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль;
- Төрийн тусгай хамгаалалтын тухай

хууль;
- Улсын хилийн тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Иргэний нисэхийн багц дүрэм, тэдгээрийн зөвлөмжийн цувралууд;
- бусад.

Дөрөв. Иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар иргэний нисэхийн болон бусад байгууллагын хүлээх үүрэг

4.1. Иргэний нисэхийн байгууллагууд нь иргэний нисэхийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа гэмт үйлдэл, үйл ажиллагаа, аюул, заналхийллийн талаархи мэдээ, мэдээллийг тануулын байгууллага болон хууль хяналтын бусад байгууллагад шуурхай мэдээлэх, хүргүүлэх, дамжуулах үүрэгтэй.

4.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид "Ерөнхий газар" гэх) нь нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага мөн. Ерөнхий газар нь Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг хариуцан дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, оролцогч байгууллагуудын үүргийг уялдуулан зохицуулах;

4.2.2. Үндэсний хөтөлбөрийг нисэх буудал, агаарын тээвэрлэгч болон бусад байгууллагуудад хүргүүлэх;

4.2.3. нисэх буудал, агаарын тээвэрлэгч, ачаа, шуудан тээвэр, нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллагуудын аюулгүй байдлын хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлтийг хянаж, баталгаажуулах;

4.2.4. нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага болон тухайн нисэх буудалд үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллагуудад нисэхийн аюулгүй байдлын судалгаа, аудит, үзлэг шалгалт, сорилт хийх, дүгнэлт гаргах;

4.2.5. иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг боловсруулж,

аюулгүй байдлын сургалтыг хууль хяналтын болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

4.2.6. нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх журмыг батлаж мөрдүүлэх, олон улсын нисэх буудлын хилийн бүсэд нэвтрэх журмыг хил хамгаалах байгууллагатай хамтран тогтоох;

4.2.7. гадаад улсаас Монгол Улсад нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлтийг хянаж, хүлээн зөвшөөрөх;

4.2.8. иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт, дүрэм, журмыг боловсруулах, дагаж мөрдүүлэх;

4.2.9. хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, үйл ажиллагаанд үнэлэлт өгч, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх.

4.3. Нисэх буудал нь тухайн нисэх буудал дээр явагдаж байгаа иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1. үндэсний хөтөлбөр болон хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, заавар болон тухайн нисэх буудлын үйл ажиллагааны онцлогт нийцсэн нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

4.3.2. нисэх буудлын аюулгүй байдлын хороог байгуулах;

4.3.3. нисэхийн аюулгүй байдлын үзлэг, шалгалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;

4.3.4. өргөтгөлийн ажил хийх, тоног төхөөрөмж шинээр байрлуулах, суурилуулах ажлыг аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр зөвхөн Ерөнхий газрын шийдвэрээр гүйцэтгэх;

4.3.5. хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний зааварчилгааг багтаасан онцгой байдлын үед ажиллах журам боловсруулан хэрэгжүүлэх;

4.3.6. онцгой байдлын үйл ажиллагааг зохицуулах төвийг байгуулах.

4.4. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллага нь тусгай гэрчилгээтэй байна. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1. хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэх олгож, хяналт тавих;

4.4.2. нисэх буудлын хориотой бүсэд нэвтрэх хүмүүс, зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаа, шуудангийн илгээмж,

агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлт аюулгүй байдлын үзлэг хийх;

4.4.3. ажилтнуудаа иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу сургаж, дадлагажуулах;

4.4.4. аюулгүй байдлын үзлэгийг зөвхөн эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;

4.4.5. нисэхийн аюулгүй байдлын дүрэм, журамд нийцсэн үйлчилгээ үзүүлэх.

4.5. Агаарын тээвэрлэгч нь иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.5.1. агаарын хөлөг, зорчигч болон тээш, ачаа, шуудан хадгалах талбайн аюулгүй байдлыг хангах, эсхүл аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

4.5.2. хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зааварчилгааг багтаасан, үндэсний хөтөлбөрийн шаардлагад нийцсэн аюулгүй байдлын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

4.5.3. онцгой байдлын үед ажиллах журам боловсруулах;

4.5.4. аюулгүй байдал хариуцсан албан тушаалтныг томилох;

4.5.5. аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ажилтнуудыг сургаж, дадлагажуулах.

4.6. Тагнуулын байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдал болон түүнд нөлөөлөх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл цуглуулан задлан шинжилгээ хийж, дүгнэлт гарган хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлнэ.

4.7. Цагдаагийн байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах ажлыг иргэний нисэхийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

Цагдаагийн байгууллага нь дараахь үүрэгтэй байна:

4.7.1. иргэний нисэхийн байгууламжид гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах;

4.7.2. хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, тэсрэх бодис хэрэглэхээр сүрдүүлэх, нисэх буудал болон түүний байгууламжид халдах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед авах арга хэмжээ, үйл ажиллагааг нисэх буудлын онцгой байдлын үед ажиллах зурмын дагуу хэрэгжүүлэх.

4.7.3. цагдаагийн албан хаагчдыг нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу сургаж, дадлагажуулах.

4.8. Хил хамгаалах байгууллага нь дараахь үүрэгтэй. Үүнд:

4.8.1. иргэний нисэхийн үйл ажиллагаанд заналхийлэл учруулах магадлал бүхий этгээдийг илрүүлэх зорилгоор ирэх болон явах зорчигчийн талаархи мэдээллийг шалгах, шаардлагагай үед холбогдох мэдээллийг иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллагад хүргүүлэх;

4.8.2. Ерөнхий газрыг шаардлагатай мэдээллээр хангах.

4.9. Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд энэхүү хөтөлбөрт заасан шаардлагуудыг биелүүлэх үүрэгтэй.

4.10. Хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллага, нисэх буудалд гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага нь ажилтнаа нисэхийн аюулгүй байдлын холбогдох сургалтад хамруулах, бусад буудлын хориотой, хамгаалагдсан болон үзлэгийн дараахь бусад нэвтрэх журмыг биелүүлэх үүрэгтэй.

4.11. Нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллага нь хоол хүнс болон агаарын хөлгийн хангалтад хэрэглэх эд зүйлд эвсвэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бусад аюултай зүйлийг нуун нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар аюулгүй байдлын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

4.12. Хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллага, нисэх буудалд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагууд нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нисэхийн аюулгүй байдлыг хангах талаар Ерөнхий газар, таниуулын болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллана.

Төв, Хамтын ажиллагаа

5.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, таниуулын байгууллага, гаалийн байгууллага, цагдаагийн байгууллага, улсын хил хамгаалах байгууллага, тогтмол нислэг гүйцэтгэдэг агаарын тээврийн байгууллагын төлөөлөл бүхий Иргэний

нисэхийн аюулгүй байдлын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) байна.

5.2. Зөвлөл нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, түүнийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулна.

5.3. Зөвлөлийн дарга нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

5.4. Зөвлөл нь дараахь бүрэн эрхтэй:

5.4.1. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

5.4.2. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах асуудлаар Ерөнхий газарт зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

5.4.3. иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед бий болсон онцгой нөхцөл байдлыг зохицуулах, шийдвэр гаргах;

5.4.4. нисэхийн аюулгүй байдлын үзлэг, шалгалтын техник, технологийн шинэчлэлт хийх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаархи зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх;

5.4.5. иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

5.4.6. иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарч болзошгүй хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоох, түүний хор уршгийг арилгахад иргэний нисэхийн байгууллага, аж ахуйн нэгжийн хүч, хэрэгслийг татан оролцуулах, иргэний нисэхийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны уялдааг хангах;

5.4.7. нисэх буудлын аюулгүй байдлын хорооноос гаргасан зөвлөмжийг хянан хэлэлцэж, шийдвэр гаргах;

5.4.8. жил бүрийн 2 дугаар сард багтаан иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар тайлан бэлтгэж холбогдох газруудад хүргүүлэх;

5.4.9. иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг хэлэлцэх;

5.4.10. нислэгийн үеийн аюулгүй байдлын ажилтан ажиллуулах талаар гадаад, дотоодын агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

5.5. Зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааны шийдвэр, протоколыг гишүүн бүрт хүргүүлнэ. Зөвлөлийн хуралд техникийн шинжээч, мэргэжилтнүүдийг урьж оролцуулж болно.

5.6. Ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар Олон улсын иргэний

нисэхийн байгууллага болон бусад улс оронтой хамтран ажиллана.

5.7. Гадаад орны эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд Ерөнхий газар нь Үндэсний хөтөлбөрийн шаардлагатай хэсгийг хүргүүлж болно.

5.8. Гадаад орны эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасны дагуу Ерөнхий газар нь тухайн улсын агаарын тээвэрлэгчийн нислэгт аюулгүй байдлын тусгай болон нэмэлт арга хэмжээг авна.

5.9. Ерөнхий газар нь аль нэг улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюул заналхийлж байгаа талаар олж авсан мэдээллийг Зөвлөлд болон тухайн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

5.10. Ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг шаардлагатай үед гадаад орны эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж, мэдээлэл, санал солилцон хамтран ажиллана.

5.11. Ерөнхий газар нь нууцын зэрэглэлтэй мэдээ, мэдээллийг хамгаалах талаар тагнуулын болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

5.12. Гадаад орны эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд Ерөнхий газар нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хийсэн аудитын тайлан болон илэрсэн дутагдлыг залруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаархи мэдээллийг хүргүүлж болно.

5.13. Монгол Улсын Засгийн газар нь энэхүү хөтөлбөрийн 4.2-т заасан иргэний нисэхийн аюулгүй байдлын үүрэг бүхий байгууллагын тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэнэ.

5.14. Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, гадаад улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах талаар холбогдох заалтыг тусгасан байна.

Зургаа. Нисэх буудлын аюулгүй байдал

6.1. Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрийг нисэх буудал хэрэгжүүлнэ.

6.2. Нисэх буудал нь нисэх буудлын хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсийг Ерөнхий газартай хамтран тогтооно.

6.3. Хориотой бүсийг нисэх буудал тогтооно.

6.4. Хориотой, хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсийг тогтоосон бүдүүвч зургийг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт хавсаргана.

6.5. Нисэх буудлын гадна орших агаарын навигацийн байгууламж нь хамгаалагдсан бүстэй байна.

6.6. Нисэх буудлын гадна орших хамгаалагдсан бүсийн аюулгүй байдал, хамгаалалтыг нисэх буудал хариуцна.

6.7. Нисэх буудлын хамгаалагдсан бүсийн аюулгүй байдлыг хашаа, хаалт байгуулах, дохиол, гэрэлтүүлэг болон камерын хяналтын систем суурилуулах, харуул хамгаалалтын ажилтан томилох замаар хангана.

6.8. Нисэх буудал нь хориотой бүсэд тээврийн хэрэгсэл, хүмүүсийг нэвтрүүлэхдээ аюулгүй байдлын үзлэг хийнэ.

6.9. Хаалга, цонх, цахилгаан шат, хонгил зэрэг бусад гарцыг зөвшөөрлийн дагуу ашиглаагүй тохиолдолд хаалтаар хамгаалсан байна.

6.10. Перрон, агаарын хөлгийн зогсоолын талбай болон онцгой анхаарлын цэг нь гэрэлтүүлэгтэй байна.

6.11. Нисэх буудал нь нийтийн эзэмшлийн бүсэд хяналт тавьж, эргүүл гаргана.

6.12. Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэхэд олгох үнэмлэхийг хүсэлт гаргагчийн анкетыг шалгасны үндсэн дээр олгоно. Нэвтрэх үнэмлэхэд дор дурдсан зүйлийг тусгана:

6.12.1. үнэмлэх эзэмшигчийн зураг, эцэг/эхийн болон өөрийн нэр, эрхэлж байгаа ажил, албан тушаал;

6.12.2. үнэмлэхийн хүчинтэй байх хугацаа;

6.12.3. үнэмлэхийн хүчин төгөлдөр үйлчлэх бүс;

6.12.4. үнэмлэхийг ашиглахтай холбогдсон зааварчилгаа

6.13. Зорчигчийг иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт нислэгийн тийэ болон суугчийн талоньг шалгасны үндсэн дээр нисэх буудлын хориотой бүсэд нэвтрүүлнэ.

6.14. Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхийг тухайн тээврийн хэрэгсэл нь нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан олгоно.

6.15. Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхэд дор дурдсан зүйлийг тусгана.

6.15.1. тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар;

6.15.2. тээврийн хэрэгслийн өмчлөгч болон жолоочийн нэр;

6.15.3. үнэмлэхний хүчинтэй байх хугацаа;

6.15.4. үнэмлэх хүчин төгөлдөр үйлчлэх бус;

6.15.5. үнэмлэхийг ашиглахтай холбогдсон зааварчилгаа.

6.16. Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх тээврийн хэрэгслийн тоонд хязгаарлалт тогтоож болно.

6.17. Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх тээврийн хэрэгсэл дотор зөвшөөрөлгүй хүн, эд зүйлс нэвтрүүлэхийг хориглоно.

6.18. Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх хүн, тэдгээрийн эд зүйлс, тээврийн хэрэгсэлд хийх аюулгүй байдлын үзлэг, шалгалтын журмыг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт тусгана.

Долоо. Агаарын хөлгийн аюулгүй байдал

7.1. Агаарын тээвэрлэгч нь өөрийн агаарын хөлгийн аюулгүй байдлыг хариуцна.

7.2. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөгт аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийх, түүнд хяналт тавих үүрэгтэй.

7.3. Агаарын тээвэрлэгч нь үйлчилгээнд гарах агаарын хөлгийг нислэг үйлдэхээр хориотой бүсэд нэвтрэхийн өмнө, шаардлагатай тохиолдолд хориотой бүсэд байрлуулсны дараа агаарын хөлгийн аюулгүй байдлын шалгалтыг хийнэ.

7.4. Агаарын тээвэрлэгч нь үйлчилгээнд гарсан агаарын хөлөгт агаарын хөлгийн аюулгүй байдлын үзлэг хийнэ.

7.5. Агаарын тээвэрлэгч нь үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах талаар дараахь арга хэмжээг авна:

7.5.1. зорчигч болон ачаа тээш ачих, буулгах төхөөрөмжийг холдуулах;

7.5.2. агаарын хөлгийн бүх хаалгыг хаах, түгжих, лацдах.

7.6. Агаарын хөлөгт дор дурдсанаас бусад этгээдийг суух, нэвтрэхийг хориглоно:

7.6.1. албан үүргээ гүйцэтгэж байгаа зохих үнэмлэх бүхий агаарын тээвэрлэгчийн болон үйлчилгээний ажилтан;

7.6.2. тухайн агаарын хөлгөөр үйлдэх нислэгээр зорчих тийз, суугчийн талон бүхий зорчигч.

7.7. Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын тээвэрлэгч нь тийз, нислэгийн захиалгын хуудас, суугчийн талон, тээшний зүүлт, шуудангийн лац болон ачааны баримт бичгийг өөрийн хяналт хамгаалалтад байлгана.

7.8. Агаарын тээвэрлэгч нь зөвшөөрөлгүй этгээд нисэх багийн бүхээгт орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Нисэх багийн бүхээгийн хаалга нь нислэгийн үед түгжээтэй байна.

Найм. Зорчигч, тэдгээрийн гар тээшний аюулгүй байдал

8.1. Нисэх буудал нь аяллаа эхэлж байгаа болон шилжин суух, дамжин өнгөрөх зорчигч, тэдгээрийн гар тээшинд хориотой бүс болон үзлэгийн дараахь бүсэд нэвтрэхээс өмнө аюулгүй байдлын үзлэг хийнэ.

8.2. Зорчигчдод аюулгүй байдлын үзлэгийг дараахь аргыг ашиглаж хийнэ:

8.2.1. гараар шалгах;

8.2.2. металл илрүүлэгч төхөөрөмжөөр шалгах.

8.3. Зорчигч, тэдгээрийн гар тээшинд хийх аюулгүй байдлын үзлэгийн журмыг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт тусгана.

8.4. Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, иргэнийг аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлнө.

8.5. Зорчигчийн гар тээшинд аюулгүй байдлын үзлэгийг дараахь аргаар хийнэ:

8.5.1. гараар шалгах;

8.5.2. рентген туяаны төхөөрөмжөөр шалгах;

8.5.3. тэсэрч дэлбэрэх бодис илрүүлэх төхөөрөмжөөр шалгах.

8.6. Рентген туяаны төхөөрөмжөөр зорчигчийн гар тээшинд аюулгүй байдлын үзлэг хийхэд сэжиг бүхий зүйл илэрсэн тохиолдолд тухайн зорчигчийг байлцуулан гараар шалгана. Шалгалтын үед тухайн зорчигчийг эд зүйлсэд хүргэхгүй, ойртуулахгүй байна.

8.7. Рентген туяаны төхөөрөмжөөр үзлэг хийсэн нийт зорчигчийн гар тээшний 10-аас доошгүй хувьд сонгох журмаар гараар шалгалт хийнэ.

8.8. Рентген туяаны төхөөрөмж ажиллаагүй тохиолдолд гар тээшинд гараар шалгалт хийнэ. Гараар шалгалт хийхдээ тухайн гар тээш, түүнд агуулагдаж байгаа эд зүйлсийг нэг бүрчлэн шалгана.

8.9. Их хэмжээний үнэт зүйл авч яваа зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй болон зүрхний аппараттай зорчигчдоод аюулгүй байдлын үзлэгийг тусад нь хийнэ.

8.10. Нисэх буудлын хориотой болон үзлэгийн дараахь бүсэд нэвтрэх нисэх бүрэлдэхүүн, хилийн хяналтын байгууллага, төрийн хамгаалалт болон үйлчилгээний ажилтнууд аюулгүй байдлын үзлэгт хамрагдана.

8.11. Дипломат эрх бүхий ажилтан аюулгүй байдлын үзлэгт хамрагдана. Дипломат эрх бүхий ажилтны гар тээш, тээшинд үзлэг хийхдээ дипломат харилцааны тухай Венийн конвенцийн (1961) холбогдох заалтын дагуу өөрийг нь, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулна.

8.12. Зохих журмын дагуу лацадсан дипломат шуудангийн илгээмжид аюулгүй байдлын үзлэг хийхгүй. Төрийн нууцын зэрэглэлтэй ачаа, шуудангийн илгээмжид зөвхөн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар аюулгүй байдлын үзлэг хийнэ.

8.13. Ажил үүргээ гүйцэтгэж яваа хууль хяналтын байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын ажилтан нь зорчигчийн бүхээгт зэвсэг, хэрэгслийг биедээ авч явах тохиолдолд дараахь шаардлагыг хангасан байна:

8.13.1. эрх бүхий байгууллагын зэвсэг авч явах зөвшөөрөл байх;

8.13.2. нислэгийн үед согтууруулах ундааны зүйлээр үйлчлэхгүй байх;

8.13.3. зэвсэг авч яваа зорчигчийн тоо болон тэдгээрийн суудлын байршлыг нислэг эхлэхээс өмнө агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байх;

8.13.4. зэвсэг авч яваа зорчигч агаарын хөлөгт суухаас өмнө холбогдох дүрэм, журмын талаар зааварчилгаа авсан байх.

8.14. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй зэвсгийг агаарын хөлгийн зорчигчийн бүхээгээс бусад хэсэгт дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд тээвэрлэнэ:

8.14.1. зэвсэг цэнэггүй байх;

8.14.2. зэвсэг нислэгийн үед хэн ч хүрэх боломжгүй газар байрласан байх.

8.15. Хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа зорчигч, бие даан зорчих чадваргүй

сэтгэцийн өвчтэй зорчигч, эсхүл Монгол Улсаас албадан гаргаж байгаа болон тухайн улсад нэвтрүүлэхийг хориглосон этгээдийг тээвэрлэх талаар холбогдох байгууллага нь агаарын тээвэрлэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

8.16. Монгол Улсад нэвтрүүлэхийг хориглосон, эсхүл Монгол Улсаас албадан гаргаж байгаа зорчигчийг агаарын хөлгөөр тээвэрлэх талаар холбогдох байгууллага нь дамжин өнгөрөх болон очих улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэж, тэдгээрийн учруулж болзошгүй аюул заналхийллийн талаархи мэдээллийг урьдчилан хүргүүлнэ.

8.17. Агаарын тээвэрлэгч нь хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэхэд тавигдах аюулгүй байдлын арга хэмжээ, журмыг өөрийн аюулгүй байдлын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ.

8.18. Агаарын тээвэрлэгч нь хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа зорчигчийг харгалзагчийн хамт, бие даан зорчих чадваргүй сэтгэцийн өвчтэй зорчигчийг асран хамгаалагчийн хамт тус тус тээвэрлэнэ.

8.19. Аюулгүй байдлын үзлэгээр зэвсэг, тээсэрч дэлбэрэх бодис болон тээсэлгээний хэрэгсэл илэрсэн тохиолдолд хураан авч тагнуулын болон цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

8.20. Эрх бүхий байгууллагаас тээвэрлэхийг зөвшөөрсөн зэвсэг, тээсэрч дэлбэрэх бодис болон тээсэлгээний хэрэгсэл, аюултай эд зүйлийг зорчигчдоос тусгаарлан агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэнэ.

8.21. Аюулгүй байдлын үзлэгээс татгалзсан болон зайлсхийсэн зорчигчийг үзлэгийн дараахь бүсэд нэвтрүүлэхгүй бөгөөд агаарын хөлгөөр тээвэрлэхгүй.

8.22. Аюулгүй байдлын үзлэгээр ороогүй зорчигч үзлэгийн дараахь бус болон агаарын хөлөгт нэвтэрсэн тохиолдолд дараахь арга хэмжээг авна.

